

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 12-ны 187 тоот
тушаалын 10 дугаар хавсралт*



ИНД - 65

Иргэний нисэхийн дүрэм

**Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны
үнэмлэх, зэрэглэл**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-65 нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний (НХҮ) ажилтны үнэмлэх, зэрэглэл олгоход тавих шаардлага болон тухайн үнэмлэх, зэрэглэлд хамаарах нөхцөл, эрх ба хязгаарлалтыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-65-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-65, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 03 сарын 16
Нэмэлт өөрчлөлт 1	2002 оны 09 сарын 17
Нэмэлт өөрчлөлт 2	2005 оны 09 сарын 14
Нэмэлт өөрчлөлт 3	2010 оны 04 сарын 16
Нэмэлт өөрчлөлт 4	2011 оны 12 сарын 12
Нэмэлт өөрчлөлт 5	2013 оны 01 сарын 11
Нэмэлт өөрчлөлт 6 (Шинэчлэлт)	2019 оны 06 сарын 12

Тэмдэглэл: ИНД-65-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 65-ын 2015 оны 09 сарын 24-ний А.5-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	1
65.1. Хамрах хүрээ.....	1
65.3. Нэр томъёо ба товчлол.....	1
65.5. Үнэмлэх, зэрэглэлийн шаардлага.....	1
65.7. Үнэмлэх, зэрэглэл.....	1
65.9. Нөөц.....	2
65.11. Үнэмлэх, зэрэглэл эзэмших хүсэлт гаргах.....	2
65.13. Үнэмлэх, зэрэглэл олгох.....	2
65.15. Үнэмлэх, зэрэглэлийн хугацаа.....	2
65.17. Шалгалт.....	3
65.19. Шалгалтын үед зөвшөөрөхгүй үйлдэл.....	3
65.21. НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэр - Ерөнхий шаардлага.....	3
65.23. НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт цаг тооцох.....	3
65.25. Эрүүл мэндийн шаардлага.....	4
65.26. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалт (19.403).....	4
65.27. Ур чадварын шалгалт.....	4
65.29. Согтууруулах ундаа, эсхүл эмийн бодистой холбоотой гэмт хэрэг.....	4
В Бүлэг - Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх	5
65.51. Хамрах хүрээ.....	5
65.53. Нөхцөл хангах шаардлага.....	5
65.55. Эрх, хязгаарлалт.....	6
С Бүлэг - Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх	6
65.101. Хамрах хүрээ.....	6
65.103. Нөхцөл хангах шаардлага.....	6
65.105. Эрх.....	7
65.107. Туршлага хадгалах шаардлага.....	8
Д Бүлэг - Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх	8
65.151. Хамрах хүрээ.....	8
65.153. Нөхцөл хангах шаардлага.....	8
65.155. Эрх, хязгаарлалт.....	9
Е Бүлэг - Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх	9
65.201. Хамрах хүрээ.....	9
65.203. Нөхцөл хангах шаардлага.....	9
65.205. Эрх, хязгаарлалт.....	10
Ғ Бүлэг - Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл	10
65.251. Хамрах хүрээ.....	10
65.253. Нөхцөл хангах шаардлага.....	10
65.255. Зэрэглэл олгох.....	11
65.257. Эрх, хязгаарлалт.....	11

Г Бүлэг - Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл	11
65.301. Хамрах хүрээ	11
65.303. Нөхцөл хангах шаардлага	12
65.305. Зэрэглэл олгох	13
65.307. Эрх, хязгаарлалт	14
65.309. Туршлага хадгалах шаардлага	14
Н Бүлэг - Нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл.....	15
65.351. Хамрах хүрээ	15
65.353. Нөхцөл хангах шаардлага	15
65.355. Зэрэглэл олгох	15
65.357. Эрх, хязгаарлалт	16
65.359. Туршлага хадгалах шаардлага	16
И Бүлэг - НХҮ-ний багшийн зэрэглэл	17
65.401. Хамрах хүрээ	17
65.403. Нөхцөл хангах шаардлага	17
65.405. Эрх, хязгаарлалт	17
Ж Бүлэг - НХҮ-ний шалгагчийн зэрэглэл.....	18
65.451. Хамрах хүрээ	18
65.453. Нөхцөл хангах шаардлага	18
65.455. Эрх, хязгаарлалт	19

А Бүлэг - Ерөнхий зүйл

65.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) НХҮ-ний ажилтны үнэмлэх болон зэрэглэл олгох;
- (2) тухайн үнэмлэх, зэрэглэл шаардлагатай нөхцөл;
- (3) тухайн үнэмлэх, зэрэглэлийн эрх, хязгаарлалт.

65.3. Нэр томьёо ба товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

65.5. Үнэмлэх, зэрэглэлийн шаардлага

(а) ИНД-172.1-д заасан агаарын зайд НХҮ үзүүлэх этгээд нь тухайн үйлчилгээг зөвхөн ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагын эрхийн хүрээнд үзүүлж болох ба дараах үнэмлэх, зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх;
- (2) энэ Дүрмийн дагуу олгосон бөгөөд зөвшөөрсөн хүчинтэй зэрэглэл.

(б) Энэ дүрмийн 65.405-д заасан НХҮ-ний багшийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.

(с) Энэ дүрмийн 65.455-д заасан НХҮ-ний шалгагчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.

65.7. Үнэмлэх, зэрэглэл

(а) Дарга, энэ Дүрмийн холбогдох шаардлагын дагуу НХҮ-ний ажилтны дараах үнэмлэх болон зэрэглэл олгож болно:

- (1) сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх;
- (2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх;
- (3) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх;
- (4) нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх;
- (5) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл;
- (6) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн дараах зэрэглэл:
 - (i) аэродромын удирдлагын зэрэглэл;
 - (ii) ойртолтын процедур-удирдлагын зэрэглэл;
 - (iii) ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэл;
 - (iv) бүсийн процедур-удирдлагын зэрэглэл;
 - (v) бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл;

- (7) нислэгийн мэдээллийн ажилтны дараах зэрэглэл:
 - (i) аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл;
 - (ii) бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл;
- (8) НХҮ-ний Багшийн зэрэглэл;
- (9) НХҮ-ний Шалгагчийн зэрэглэл.

(b) НХҮ-ний багшийн болон НХҮ-ний шалгагчийн зэрэглэлийг тухайн эзэмшигчийн үнэмлэхэнд тэмдэглэсэн байх ёстой.

(c) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад зэрэглэл болон энэ Дүрмийн дагуу НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигчид олгосон зөвшөөрлийг тухайн үнэмлэх эзэмшигчийн НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт тэмдэглэсэн байх ёстой ба үнэмлэхэнд нь бичиж болно.

65.9. Нөөц

65.11. Үнэмлэх, зэрэглэл эзэмших хүсэлт гаргах

НХҮ-ний ажилтны үнэмлэх, НХҮ-ний багшийн зэрэглэл, эсхүл НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмших, эсхүл тухайн үнэмлэхний бусад зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэл хийлгэх хүсэлт гаргагч нь САА 24065/01 маягыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.

65.13. Үнэмлэх, зэрэглэл олгох

Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн дагуу үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч нь тохирох зөв хүн байх;
- (2) хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгэхэд шаардагдах монгол болон англи хэлээр унших, бичих, ярих, ойлгох чадвартай байх;
- (3) хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгохтой холбоотой энэ Дүрэмд заасан бүх нөхцөл хангах шаардлагыг хангасан байх;
- (4) тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

65.15. Үнэмлэх, зэрэглэлийн хугацаа

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэлийг Хуулийн дагуу түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгоогүй бол тухайн эзэмшигчийн насан туршид хүчинтэй байна.

(b) Дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд түр үнэмлэх, эсхүл зэрэглэл олгож болно.

65.17. Шалгалт

(а) Энэ Дүрмийн дагуу бичгийн шалгалт өгөх этгээд нь:

- (1) өөрийгөө нотлох баримт бичгийг биедээ авч явах;
- (2) өндөр босго үнэлгээ шаардсанаас бусад шалгалтад тэнцэхийн тулд боломжит үнэлгээний 70%-иас доошгүйг авсан байна.

(b) Энэ Дүрмээр шаардсан шалгалт авч байгаа байгууллага нь шалгалт өгсөн этгээдийн хангалтгүй мэдлэгийн зөрүүг тодорхойлох ба шалгалтад тэнцсэн дүгнэлт гаргахаас өмнө эдгээр мэдлэгийн зөрүүг арилгасныг бататгана.

65.19. Шалгалтын үед зөвшөөрөхгүй үйлдэл

(а) Энэ Дүрмийн дагуу шалгалтын үед, аливаа этгээд нь шалгалт авч байгаа ажилтан зөвшөөрснөөс бусад тохиолдолд, дараах үйлдлийг хийхгүй байх үүрэгтэй:

- (1) бусад этгээдээс хуулах; эсхүл
- (2) мэдээллийн эх үүсвэр ашиглах; эсхүл
- (3) шалгалт авч байгаа ажилтнаас бусад этгээдтэй аливаа арга замаар харьцах; эсхүл
- (4) бусдын өмнөөс шалгалт өгөх; эсхүл
- (5) шалгалтын материалыг авч гарах; эсхүл
- (6) шалгалтын бичлэгийг цахим хэлбэрээр хийх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан аль нэг үйлдлийг хийсэн этгээдэд дараах арга хэмжээг бүгдийг, эсхүл хэсэгчлэн авна:

- (1) тухайн сэдвийн шалгалтад тэнцээгүйд тооцох;
- (2) өмнө нь тэнцсэн шалгалтын сэдвийг бүгдийг, эсхүл хэсэгчлэн хүчингүйд тооцох;
- (3) цаашид ИНД-ийн дагуу өгөх шалгалтад 12 сар хүртэл хугацаанд оруулахгүй байх;
- (4) тухайн этгээдэд энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох.

65.21. НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэр - Ерөнхий шаардлага

НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигч нь:

- (1) НХҮ-ний сургалт болон туршлагаа Даргын хүлээн зөвшөөрөхүйц НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт байнгын хувиршгүй хэлбэрээр бичнэ;
- (2) үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлтэд холбогдох бүртгэлийг баримтаар хүргүүлэхдээ, хамгийн сүүлд оруулсан мэдээллийн төгсгөлд, дээр оруулсан мэдээллүүд нь үнэн зөв болохыг баталгаажуулж, гарын үсэг зурсан байна.

65.23. НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт цаг тооцох

(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигч нь, НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигчийн, НХҮ-ний багшийн, эсхүл НХҮ-ний шалгагчийн үүрэг гүйцэтгэсэн цагийг НХҮ-ний нийт цагт оруулж тооцох эрхтэй.

(b) Энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаагүй байх үедээ тухайн цагийг энэ Дүрмийн дагуу аливаа зорилгод оруулж тооцохгүй.

65.25. Эрүүл мэндийн шаардлага

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, эсхүл нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхгүй:

- (1) ИНД-67-гийн дагуу олгосон 3-р ангиллын хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;
- (2) тухайн ЭМГ-ний бүх эрүүл мэндийн баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх.

65.26. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалт (19.403)

Дарга, дараах нөхцөлийг харгалзан нислэгийн хөдөлгөөний удирдагчийн албан үүргээ гүйцэтгэхэд зарцуулж болох хугацаанд үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалтыг тогтоож болно:

- (1) ажлын байрны төрөл;
- (2) өдрийн аль цагт тухайн ажил үүргийг гүйцэтгэх;
- (3) тухайн байрлал, нислэгийн хөдөлгөөний нягтаршил, эсхүл нислэгийн хөдөлгөөний удирдагчид шаардлагатай оюуны төвлөрөлтийн түвшинд нөлөөлөх бусад хүчин зүйл.

65.27. Ур чадварын шалгалт

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь Даргын тогтоосон хугацаанд, эзэмшиж байгаа үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хүрээнд Даргын шаардлагатай гэж үзсэн ур чадварын хадгалалтын шалгалт, эсхүл тестийг өгсөн байна.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шалгалт, эсхүл тест өгсөн этгээд нь үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихэд тавих шаардлагыг хангаагүй бол тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхгүй.

65.29. Согтууруулах ундаа, эсхүл эмийн бодистой холбоотой гэмт хэрэг

Согтууруулах ундаа, эсхүл эмийн бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох хуулийн дагуу тест өгөхөөс татгалзсан үйлдлийг багтаасан, согтууруулах ундаа, эсхүл эмийн бодистой холбоотой шүүхийн шийтгэл нь тухайн этгээдийг үнэмлэх эзэмшихэд тохирох зөв хүн хэвээр байгаа эсэхийг дахин тогтоох үндэслэл болно. Тухайн шийтгэл нь үнэмлэх олгохоос татгалзах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоход нөлөөлж болно.

В Бүлэг - Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх

65.51. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх олгох;
- (2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.

65.53. Нөхцөл хангах шаардлага

(a) Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) 18 нас хүрсэн байх;
- (2) ИНД-67-гийн дагуу олгосон 3-р ангиллын хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;
- (3) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшдэг байх;
- (4) хяналттай агаарын зайд, агаарын хөлгийн нислэгийн бүхээгт 2-оос доошгүй цаг танилцах дадлага хийсэн туршлагатай байх;
- (5) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэгт ажилд хамаарах дараах сэдвийг багтаасан сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:
 - (i) *Нисэхийн хууль, дүрэм*: Дүрэм, журам;
 - (ii) *НХУ-ын төхөөрөмж*: НХУ-д ашигладаг төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт;
 - (iii) *Агаарын хөлгийн ерөнхий мэдлэг*: нислэгийн зарчим; агаарын хөлөг, хүчний төхөөрөмж, системийн ажиллагаа болон ажиллах зарчим; агаарын хөлгийн үзүүлэлт;
 - (iv) *Хүний хүчин зүйл*: төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;
 - (v) *Цаг уур*: нисэхийн цаг уур; цаг уурын баримт бичиг, мэдээллийг ашиглах, түүнийг үнэлэх; нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх цаг агаарын аюултай үзэгдлийн гарал үүсэл, шинж чанар; өндөр хэмжих;
 - (vi) *Навигаци*: агаарын навигацийн үндсэн зарчим; навигацийн систем болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний зарчим, хязгаарлалт болон нарийвчлал;
 - (vii) *Үйл ажиллагааны журам*: НХУ, харилцаа холбоо, радио холбоо, нислэгийн холбооны стандарт хэллэгийн журам (хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн); холбогдох нисэхийн бичиг баримтыг ашиглах; нислэгтэй холбоотой аюулгүй байдлын практик.

(b) Энэ зүйлийн (a)(5)-д амжилттай дүүргэсэн байхыг шаардсан сургалтыг дараах байгууллага зохион байгуулна:

- (1) ИНД-172-ын дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл

- (2) Конвенцийн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол.

65.55. Эрх, хязгаарлалт

Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх нь тухайн эзэмшигчид, дараах зорилгоор НХУ-ын ажлын дадлага туршлага олж авах НХУ-ын ажил үүргийг, НХУ-ний багшийн зэрэглэл эзэмшигчийн хяналтан дор гүйцэтгэх эрхийг олгоно:

- (1) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрөл авахаар мэргэших; эсхүл
- (2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн хүчинтэй байдлыг сэргээх.

С Бүлэг - Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх

65.101. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх олгох;
- (2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.

65.103. Нөхцөл хангах шаардлага

(а) Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, эсхүл Конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас олгосон хүчинтэй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) 21 нас хүрсэн байх;
- (3) дараах туршлагатай байх:
 - (i) энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхийг 3 сараас доошгүй хугацаанд хэрэгжүүлсэн; эсхүл
 - (ii) Конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхийг тухайн улсад 2-оос доошгүй жил хэрэгжүүлсэн.
- (4) хяналттай агаарын зайд, агаарын хөлгийн нислэгийн бүхээгт 10-аас доошгүй цаг дадлага хийсэн туршлагатай байх;
- (5) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэгт ажилтай холбоотой шалгалтыг дараах сэдвээр амжилттай өгсөн байх:
 - (i) *Нисэхийн хууль, дүрэм*: Дүрэм, журам;
 - (ii) *НХУ-ын төхөөрөмж*: НХУ-д ашиглагдах төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт;

- (iii) *Агаарын хөлгийн ерөнхий мэдлэг*: нислэгийн зарчим; агаарын хөлөг, хүчний төхөөрөмж, системийн ажиллагааны болон ажиллах зарчим; агаарын хөлгийн үзүүлэлт;
 - (iv) *Хүний хүчин зүйл*: төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;
 - (v) *Цаг уур*: нисэхийн цаг уур; цаг уурын баримт бичиг, мэдээллийг ашиглах, түүнийг үнэлэх; нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх цаг агаарын аюултай үзэгдлийн гарал үүсэл, шинж чанар; өндөр хэмжих;
 - (vi) *Навигаци*: агаарын навигацийн үндсэн зарчим; навигацийн систем болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний зарчим, хязгаарлалт болон нарийвчлал;
 - (vii) *Үйл ажиллагааны журам*: НХУ, харилцаа холбоо, радио холбоо, нислэгийн холбооны стандарт хэллэгийн журам (хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн); холбогдох нисэхийн бичиг баримтыг ашиглах; нислэгтэй холбоотой аюулгүй байдлын практик;
- (б) Энэ Дүрмийн 6 Бүлгийн дагуу олгосон нэгээс доошгүй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлд тавих сургалт, туршлагын болон үнэлгээ хийх шаардлагыг хангасан байх;
- (7) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажил үүргийг чадварлагаар гүйцэтгэх чадвараа НХУ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигчид шалгуулсан байх.
- (b) Конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас олгосон хүчинтэй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшигчийг энэ зүйлийн (a)(5)-д шаардсан агаарын хөлгийн тухай ерөнхий мэдлэг, цаг уурын болон навигацийн шалгалтыг өгсөнд тооцно.
- (c) Энэ зүйлийн (a)(5)-д шаардсан шалгалтыг дараах байгууллага авна:
- (1) ИНД-172-ын дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол.

65.105. Эрх

Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх нь тухайн эзэмшигчид дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:

- (1) сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний;
- (2) НМА-ны үнэмлэхний;
- (3) эзэмшиж байгаа хүчинтэй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлийн болон зөвшөөрлийн.

65.107. Туршлага хадгалах шаардлага

Үнэмлэх эзэмшигч нь энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхийг өмнө үргэлжилсэн 5 жилийн дотор хэрэгжүүлээгүй бол тухайн үнэмлэхний эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 65.103(а)(7)-гийн шаардлагыг хангасан байна.

D Бүлэг - Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх**65.151. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх олгох;
- (2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.

65.153. Нөхцөл хангах шаардлага

(а) Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) 18 нас хүрсэн байх;
- (2) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшдэг байх;
- (3) агаарын хөлгийн нислэгийн бүхээгт 2-оос доошгүй цаг танилцах дадлага хийсэн туршлагатай байх;
- (4) НМА-ны үүрэгт ажилд хамаарах дараах сэдвийг багтаасан сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:
 - (i) *НХУ-ний ерөнхий мэдлэг*: Монгол Улсын агаарын зайд үзүүлж байгаа НХУ;
 - (ii) *Үйл ажиллагааны журам*: радио-холбооны журам, стандарт хэллэг, радио холбооны сүлжээ;
 - (iii) *Нисэхийн хууль, дүрэм*: Дүрэм, журам;
 - (iv) *Хүний хүчин зүйл*: төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;
 - (v) *Радио холбооны төхөөрөмж*: нисэхийн байгууламж дахь радио холбооны төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт.

(b) Энэ зүйлийн (а)(4)-т амжилттай дүүргэсэн байхыг шаардсан сургалтыг дараах байгууллага зохион байгуулна:

- (1) ИНД-172-ын дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол.

65.155. Эрх, хязгаарлалт

Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх нь эзэмшигчид, дараах зорилгоор НМА-ны ажлын дадлага туршлага олж авахаар НМА-ны ажил үүргийг хүчинтэй НХУ-ний багшийн зэрэглэл эзэмшигчийн хяналтан дор гүйцэтгэх эрхийг олгоно:

- (1) НМА-ны үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрөл авахаар мэргэших; эсхүл
- (2) НМА-ны үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн хүчинтэй байдлыг сэргээх.

Е Бүлэг - Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх**65.201. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) НМА-ны үнэмлэх олгох;
- (2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.

65.203. Нөхцөл хангах шаардлага

(a) НМА-ны үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэхний эрхийг 2 сараас доошгүй хугацаанд хэрэгжүүлсэн туршлагатай байх;
- (3) агаарын хөлгийн нислэгийн бүхээгт 10-аас доошгүй цаг дадлага хийсэн туршлагатай байх;
- (4) НМА-ны үүрэгт ажилд хамаарах дараах сэдвээр шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) *НХУ-ний ерөнхий мэдлэг*: Монгол Улсын агаарын зайд үзүүлж байгаа НХУ;
 - (ii) *Үйл ажиллагааны журам*: радио-холбооны журам, стандарт хэллэг, радио холбооны сүлжээ;
 - (iii) *Нисэхийн хууль, дүрэм*: Дүрэм, журам;
 - (iv) *Хүний хүчин зүйл*: төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;
 - (v) *Радио холбооны төхөөрөмж*: нисэхийн байгууламж дахь радио холбооны төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт;
- (5) Н Бүлгийн дагуу олгосон НМА-ны нэгээс доошгүй зэрэглэлд тавих сургалтын болон үнэлгээ хийх шаардлагыг хангасан байх;
- (6) НХУ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигчид, дараах ажиллагааг багтаасан НМА-ны үүргийг чадварлагаар гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх:
 - (i) зэрэглэл авахаар зорьж байгаа ажлын байранд ашиглаж байгаа радио холбооны төхөөрөмжийг ажиллуулах;

- (ii) радио-холбооны мэдээллийг үр дүнтэй, алдаагүй нягт нямбай дамжуулах, хүлээн авах.
- (b) Энэ зүйлийн (a)(4)-т шаардсан шалгалтыг дараах байгууллага авна:
 - (1) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (2) ИНД-141-ийн олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол.

65.205. Эрх, хязгаарлалт

- (a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НМА-ны үнэмлэх нь тухайн эзэмшигчид дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:
 - (1) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэхний;
 - (2) эзэмшиж байгаа хүчинтэй НМА-ны зэрэглэл болон зөвшөөрлийн.
- (b) Үнэмлэх эзэмшигч нь тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө, эзэмшиж байгаа зөвшөөрөгдсөн зэрэглэлд хамаарах нисэхийн байгууламжид ашиглагдаж байгаа төхөөрөмжийн төрөл болон үйл ажиллагааны журмын талаарх хүчинтэй мэдээлэлтэй танилцсан байна.

F Бүлэг - Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл

65.251. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) НХҮ-ний ажилтанд нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгох;
- (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт.

65.253. Нөхцөл хангах шаардлага

- (a) Энэ Дүрмийн дагуу нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:
 - (1) дараах байгууллагын зохион байгуулсан, бичгийн шалгалтыг багтаасан нисэхийн радио-холбооны дадлага болон журмын сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:
 - (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулж, шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулж, шалгалт авахыг зөвшөөрдөг бол;

- (2) НХҮ-ний багшийн зэрэглэл, эсхүл багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчид дараах чадвараа шалгуулсан байх:
- (i) нисэхийн радио-холбооны төхөөрөмжийн удирдлагыг зөв ажиллуулах болон тохируулах;
 - (ii) хүчинтэй мөрдөгдөж байгаа журмын дагуу яриан мэдээг чадварлагаар хүлээн авч, дамжуулах.

65.255. Зэрэглэл олгох

(a) НХҮ-ний багшийн зэрэглэл, эсхүл багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь, 65.253-т заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэлд тавих шаардлага хангагдсан гэж үзвэл, тухайн этгээдийн бүртгэлийн дэвтэрт өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг; нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулж, зэрэглэл олгоно:

[тухайн этгээдийн нэр] нь ИНД-65-д заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.

(b) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигч нь Даргад хүсэлт гаргаж, зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, радио-холбооны операторын зэрэглэлийг үнэмлэхэндээ нэмж тэмдэглүүлж болно.

65.257. Эрх, хязгаарлалт

Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл нь тухайн этгээдэд нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд зориулсан давтамж дээр ажилладаг агаарын хөлөг, нисэхийн радио станц, эсхүл газрын хөдөлгөөнт станцыг ажиллуулах эрх олгоно, хэрэв дамжуулагч нь:

- (1) зөвхөн энгийн гадна удирдлага ашиглахыг шаарддаг бол;
- (2) цацагдаж байгаа давтамжийн тогтвортой байдлыг автоматаар хадгалдаг бол.

Г Бүлэг - Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл

65.301. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) дараах нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл болон түүний зөвшөөрөл олгох:
 - (i) аэродромын удирдлагын зэрэглэл;
 - (ii) ойртолтын процедур-удирдлагын зэрэглэл;
 - (iii) ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэл;
 - (iv) бүсийн процедур-удирдлагын зэрэглэл;
 - (v) бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл;
- (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг тогтоох;
- (3) тухайн этгээдийн нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл нь дараах зэрэглэлд хамаарч байгаа бол:

- (i) ойртолтын удирдлагын зэрэглэлийг ойртолтын процедур-удирдлагын зэрэглэлд;
- (ii) ойртолтын радарын удирдлагын зэрэглэлийг ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэлд;
- (iii) бүсийн удирдлагын зэрэглэлийг бүсийн процедур-удирдлагын зэрэглэлд;
- (iv) бүсийн радарын удирдлагын зэрэглэлийг бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэлд тооцох.

65.303. Нөхцөл хангах шаардлага

(a) Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл болон тухайн зэрэглэлд эхний зөвшөөрөл авах этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) тухайн зэрэглэл болон зөвшөөрөлтэй холбоотой дараах сэдвээр сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:
 - (i) *аэродромын удирдлагын зэрэглэл*: аэродромын байрлалын зураг; бодит үзүүлэлт болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ, агаарын зайн бүтэц зохион байгуулалт; холбогдох хууль, дүрэм, ажлын горим, мэдээллийн эх сурвалж; агаарын навигацийн байгууламж; НХУ-ын төхөөрөмж болон түүний ашиглалт; газрын бартаа болон газар зүйн онцлог газар; нислэгийн хөдөлгөөний шинж чанар/үзүүлэлт; цаг агаарын аюултай үзэгдэл; онцгой нөхцөл болон эрэн хайх, авран туслах төлөвлөгөө;
 - (ii) *ойртолтын болон бүсийн процедур-удирдлагын зэрэглэл*: агаарын зайн бүтэц зохион байгуулалт; холбогдох хууль, дүрэм, ажлын горим, мэдээллийн эх сурвалж; агаарын навигацийн байгууламж; НХУ-ын төхөөрөмж болон түүний ашиглалт; газрын бартаа болон газар зүйн онцлог газар; нислэгийн хөдөлгөөний шинж чанар/үзүүлэлт болон хөдөлгөөний урсгал; цаг агаарын аюултай үзэгдэл; онцгой нөхцөл болон эрэн хайх, авран туслах төлөвлөгөө;
 - (iii) *ойртолтын ажиглалтын болон бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл*: тухайн хариуцлагын бүсэд хэрхэн нөлөөлөх хэмжээгээр нь энэ хэсгийн (2)(ii) дээр нэмж радар, бусад ажиглалтын систем болон холбогдох төхөөрөмжийн зарчим, хэрэглээ болон хязгаарлалт; хангалттай газрын бартааг давах зайтай болохыг бататгах журмыг багтаасан, ойртолтын, эсхүл бүсийн радарын удирдлагын үйлчилгээнд ашиглах, холбогдох журам;
- (3) НХУ-ний Багшийн зохих зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтан дор, дараах туршлагыг эзэмшсэн байх:
 - (i) *аэродромын удирдлагын зэрэглэл*: тухайн зэрэглэл авахаар зорьж байгаа аэродромд 90-ээс доошгүй цаг, эсхүл 1 сарын аль их хугацаанд аэродромын удирдлагын үйлчилгээ гүйцэтгэсэн;

- (ii) *ойртолтын процедур-удирдлагын, ойртолтын ажиглалтын-удирдлагын, бүсийн процедур-удирдлагын, бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл*: зэрэглэл авахаар зорьж байгаа удирдлагын үйлчилгээг 180-аас доошгүй цаг, эсхүл 3 сарын аль их хугацаанд тухайн зэрэглэл авахаар зорьж байгаа нэгж дээр гүйцэтгэсэн;
- (4) энэ хэсгийн (2)-т заасан сэдвээр дараах байгууллагын зохион байгуулсан, тухайн зэрэглэлийн эрхтэй холбоотой шалгалтыг амжилттай өгсөн байх:
- (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
- (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол;
- (5) зэрэглэл авахаар зорьж байгаа нэгж дээр удирдлагын үйлчилгээг аюулгүй, эрэмбэ дараатай, шуурхай үзүүлэхэд шаардлагатай ур чадвар, нөхцөл байдлыг зөв тодорхойлох болон гүйцэтгэх чадвараа НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигчид шалгуулсан байх.
- (b) Энэ зүйлийн (a)(2)-т амжилттай дүүргэсэн байхыг шаардсан сургалтыг дараах байгууллага зохион байгуулах ёстой:
- (1) энэ зүйлийн (a)(4)(i)-д заасан НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулах эрх олгодог бол; эсхүл
- (2) энэ зүйлийн (a)(4)(ii)-т заасан Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулах эрх олгодог бол.
- (c) Эзэмшиж байгаа нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлдээ нэмэлт байрлалд зөвшөөрөл авах этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:
- (1) энэ зүйлийн (a)(2)-т шаардсан нэмэлт байрлалын сургалтыг амжилттай дүүргэсэн байх;
- (2) энэ зүйлийн (a)(5)-д шаардсан нэмэлт байрлалд ажиллахад тавих шаардлагыг хангасан байх.

65.305. Зэрэглэл олгох

(a) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь, нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлд тавих 65.303(a)-ийн шаардлага хангагдсан гэж үзвэл нислэгийн хөдөлгөөний удирдагчийн бүртгэлийн дэвтэрт, олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлийг бичиж, тухайн зэрэглэлийг ашиглах нөхцөл, зөвшөөрсөн байрлалын нэр; өөрийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг, тухайн нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулна:

[нислэгийн хөдөлгөөний удирдагчийн нэр] нь дор заасан ИНД-65-ын нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл олгох шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.

(b) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлийн нэмэлт зөвшөөрөлд тавих 65.303(с)-гийн шаардлага хангагдсан гэж үзвэл нислэгийн хөдөлгөөний удирдагчийн бүртгэлийн дэвтэрт, олгосон зэрэглэлийг зөвшөөрсөн байрлалын нэр, өөрийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон нэмэлт зөвшөөрөл олгосон огноог энэ зүйлийн (а)-д шаардсан мэдэгдлийн дагуу оруулж, тухайн зэрэглэлд зөвшөөрөл олгоно.

(c) Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшигч нь Даргад хүсэлт гаргаж, зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, олгосон зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэлийг үнэмлэхэндээ нэмж хийлгэж болно.

65.307. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл нь түүнийг эзэмшигчид дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:

- (1) аэродромын удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэлд зөвшөөрсөн аэродромд, эсхүл аэродромуудад аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- (2) ойртолтын процедур-удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэлд зөвшөөрсөн аэродромд, эсхүл аэродромуудад ойртолтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- (3) ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэл: хамааралтай НХҮ-ний ажиглалтын системийг ашиглан, тухайн зэрэглэлд зөвшөөрсөн аэродромд, эсхүл аэродромуудад ойртолтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- (4) бүсийн процедур-удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэлд зөвшөөрсөн хяналттай бүс, эсхүл бүсүүдэд бүсийн удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- (5) бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл: хамааралтай ажиглалтын системийг ашиглан, тухайн зэрэглэлд зөвшөөрсөн хяналттай бүс, эсхүл бүсүүдэд бүсийн удирдлагын үйлчилгээ үзүүлэх.

(b) Эзэмшигч нь зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлж эхлэхийн өмнө, тухайн зэрэглэлтэй холбоотой хүчинтэй бүх мэдээлэлтэй танилцсан байх үүрэгтэй.

65.309. Туршлага хадгалах шаардлага

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг нэг ээлжийн үйл ажиллагааны үеэр 5-аас доошгүй цаг, өмнө үргэлжилсэн 28 өдрийн дотор шууд хяналтан дор хэрэгжүүлээгүй бол эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө, бие даан үүрэг гүйцэтгэх чадвараа НХҮ-ний багшид шалгуулсан байна.

(b) Энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг өмнө үргэлжилсэн 6 сарын хугацаанд хэрэгжүүлээгүй бол эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 65.303-ын (a)(4) болон (5)-ын шаардлагыг хангасан байна.

Н Бүлэг - Нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл

65.351. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) НМА-ны дараах зэрэглэл олгох;
 - (i) аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл;
 - (ii) бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл;
- (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт.

65.353. Нөхцөл хангах шаардлага

НМА-ны зэрэглэл болон тухайн зэрэглэлийн эхний зөвшөөрөл, эсхүл нэмэлт зөвшөөрөл авах этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) хүчинтэй НМА-ны үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) дараах байгууллагын зохион байгуулсан, тухайн зэрэглэлтэй холбоотой сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:
 - (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;
- (3) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигчид, зэрэглэл авахаар зорьж байгаа нэгж дээр нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ур чадвар, нөхцөл байдлыг зөв тодорхойлох болон гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх.

65.355. Зэрэглэл олгох

(a) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь НМА-ны зэрэглэлд тавих 65.353-ын шаардлага хангагдсан гэж үзвэл НМА-ны зэрэглэл олгож, бүртгэлийн дэвтэрт нь тухайн зэрэглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой нөхцөл, зөвшөөрсөн байрлалын нэр; багшийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг, зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулна:

[нислэгийн мэдээллийн ажилтны нэр] нь Иргэний нисэхийн дүрэм 65-д заасан нислэгийн мэдээллийн ажилтны дор дурдсан зэрэглэлийн шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.

(b) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь НМА-ны зэрэглэлийн нэмэлт зөвшөөрөлд тавих 65.353-ын шаардлага хангагдсан гэж үзвэл НМА-ны бүртгэлийн дэвтэрт зэрэглэлийг зөвшөөрсөн байрлалын нэр; багшийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон зэрэглэл олгосон огноог зэрэглэл баталгаажуулах мэдэгдлийн дагуу оруулж, тухайн зэрэглэлд зөвшөөрөл олгоно.

(с) НМА-ны үнэмлэх эзэмшигч нь Даргад хүсэлт гаргаж, зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, зөвшөөрөгдсөн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг үнэмлэхэндээ нэмж хийлгэж болно.

65.357. Эрх, хязгаарлалт

(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НМА-ны зэрэглэл нь түүнийг эзэмшигчид дараах эрхийг олгоно:

- (1) *аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл*: тухайн зэрэглэл эзэмшигчид зөвшөөрсөн аэродром, эсхүл аэродромуудад аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- (2) *бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл*: тухайн зэрэглэл эзэмшигчид зөвшөөрсөн бүс, эсхүл бүсүүдэд нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

(b) Эзэмшигч нь зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлэхийн өмнө, тухайн зэрэглэлтэй холбоотой бүх хүчинтэй мэдээлэлтэй танилцсан байна.

65.359. Туршлага хадгалах шаардлага

(а) Энэ Дүрмийн дагуу олгосон НМА-ны зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг нэг ээлжийн үйл ажиллагааны үеэр 5-аас доошгүй цаг, өмнө үргэлжилсэн 28 өдрийн дотор шууд хяналтан дор хэрэгжүүлээгүй бол эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө, бие даан үүрэг гүйцэтгэх чадвараа НХҮ-ний багшид шалгуулсан байна.

(b) Энэ Дүрмийн дагуу олгосон НМА-ны зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг өмнө үргэлжилсэн 6 сарын хугацаанд хэрэгжүүлээгүй бол эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 65.353-ын (3)-ын шаардлагыг хангасан байна.

I Бүлэг - НХҮ-ний багшийн зэрэглэл

65.401. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) НХҮ-ний Багшийн зэрэглэл олгох;
- (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт.

65.403. Нөхцөл хангах шаардлага

(a) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, эсхүл НМА-ны үнэмлэхний эрхийг 5-аас доошгүй жил хэрэгжүүлсэн туршлагатай байх;
- (3) дараах байгууллагын зохион байгуулсан онол болон практикийн зааварчилгаа өгөх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:
 - (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;
- (4) Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалт болон практик тестийг амжилттай өгч тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх чадвараа харуулсан байх.

(b) Энэ зүйлийн (a)(4)-т шаардсан шалгалт болон тестийг дараах байгууллага авна:

- (1) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол; эсхүл
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол.

(c) Энэ Дүрэм хүчинтэй болохоос өмнө 65.405-д заасантай дүйцэх эрхийг хэрэгжүүлж байсан этгээдийг энэ зүйлийн (a)-ийн нөхцөл хангах шаардлагыг хангасанд тооцно.

65.405. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НХҮ-ний Багшийн зэрэглэл эзэмшигч нь дараах эрхтэй:

- (1) НХҮ-ний ажилтанд зааварчилгаа өгөх;
- (2) сургалтад хамрагдаж байгаа, эсхүл эрхээ сэргээж байгаа НХҮ-ний ажилтны үүрэг гүйцэтгэж байгаа этгээдэд шууд хяналт тавих;
- (3) үнэлгээ хийж, НХҮ-ний зэрэглэл болон зөвшөөрөл олгох.

(b) Энэ зүйлийн (c)-г харгалзан, НХҮ-ний багшийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх эзэмшигч нь:

- (1) холбогдох үйлчилгээнд хамаарах хүчинтэй зэрэглэл болон зөвшөөрөлтэй, хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байна;
- (2) тухайн эрхийг дараах гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад хэрэгжүүлнэ:
 - (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн эрх хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг бол;
- (3) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигчид үнэлгээ хийх, зэрэглэл болон зөвшөөрөл олгохын тулд дараах шаардлагыг хангасан байна:
 - (i) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний, эсхүл НМА-ны үнэмлэхний эрхийг 5-аас доошгүй жил хэрэгжүүлсэн туршлагатай байх;
 - (ii) өмнө үргэлжилсэн 13 сарын хугацаанд НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигчид, тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх ур чадвараа шалгалтаар болон тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх үйл явцад суурилсан практик тестээр шалгуулсан байх.

(c) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь НХҮ үзүүлэх эрхээ хэрэгжүүлээгүй бол тухайн эзэмшигчийг хүчинтэй ЭМГ-тэй байхыг шаардахгүй.

Ж Бүлэг - НХҮ-ний шалгагчийн зэрэглэл

65.451. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл олгох;
- (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт.

65.453. Нөхцөл хангах шаардлага

(a) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний, эсхүл НМА-ны үнэмлэхний эрхийг 8-аас доошгүй жил хэрэгжүүлсэн туршлагатай байх;
- (3) ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд НХҮ-ний шалгагчийн үүрэг гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх.

(b) Энэ Дүрэм хүчинтэй болох үед 65.455-д заасантай дүйцэх эрхийг хэрэгжүүлж байсан этгээдийг энэ зүйлийн (a)-ийн нөхцөл хангах шаардлагыг хангасанд тооцно.

65.455. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигч нь дараах эрхтэй:

- (1) НХҮ-ний ажилтны үнэмлэх олгох, эсхүл эрх сунгах бичгийн, аман болон практик шалгалт авах;
- (2) НХҮ-ний Багшийн зэрэглэл олгох, эсхүл түүний хүчинтэй байдлыг сунгах бичгийн, аман болон практик шалгалт авах.

(b) Энэ зүйлийн (c)-г харгалзан, НХҮ-ний шалгагчийн зэрэглэлийн эрх хэрэгжүүлэх эзэмшигч нь:

- (1) холбогдох үйлчилгээний зэрэглэлтэй, хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байна;
- (2) тухайн шалгалтыг дараах гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад авна:
 - (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
 - (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол;
- (3) өмнө үргэлжилсэн 13 сарын хугацаанд, ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд НХҮ-ний шалгагчийн үүрэг гүйцэтгэх чадвараа шалгуулсан байна.

(c) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигч нь НХҮ үзүүлэх эрхээ хэрэгжүүлээгүй бол тухайн эзэмшигчийг хүчинтэй ЭМГ-тэй байхыг шаардахгүй.

--oOo--